

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 04.

Хэрлэн сум

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь даатгуулагчийг дэмжих, хамрагдалтыг нэмэгдүүлэх жилийн хүрээнд аймгийн засаг даргатай хамтран ажиллаж ажил олгогч, албан журмын даатгуулагч, сайн дурын даатгуулагчийн хамралтыг нэмэгдүүлэх арга хэмжээнд зориулан сургалт сурталчилгаа, үйл ажиллагаа зохион байгуулах 9355000 (есөн сая гурван зуун тавин таван мянган) төгрөгийн хөрөнгийг засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас гаргуулан ажилласан.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын газрын даргаар 2025 онд хийх сургалт сурталчилгааны жилийн төлөвлөгөөг батлуулан сум, багийн иргэдийн нийтийн хурал, сум, багаас зохион байгуулсан малчид, хуваариа хөдөлмөр эрхлэгч, ногоочид, тариаланчдын зөвөлгөөнд хамтран оролцсон байна. Мөн сумдын байцаагч, ажилчдыг сум, багийн иргэдийн нийтийн хуралд жилд 2-оос доошгүй удаа оролцох нөхцөл боломжоор ханган шатахууны зардлыг хуваарьлан сургалт сурталчилгаа, үйл ажиллагаа зохион байгуулах нөхцлийг сайжруулсан. Нийгмийн даатгалын газрын байцаагч албан хаагчид 1-4 дүгээр улиралд сумдад сургалт зохион байгуулах, иргэд даатгуулагчид зөвлөгөө мэдээлэл өгөх, ажил олгогч даатгуулагчидтай уулзалт хийх ажлыг зохион байгуулан дараах хуваарийн дагуу ажиллуулсан. Үүнд:

1-р улиралд Дадал, Норовлин, Баян-Адарга, Биндэр

2-р улирал Баянхутаг, Баянмөнх, Дархан, Мөрөн


3-р улиралд Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр

4-р улиралд Батширээт, Батноров, Бэрх, Бор-Өндөр

Шатахуун хуваарилалт

№	Сумдын нэр	Хугацаа	Шатахуун	Хугацаа	Шатахуун	Нийт	Гарын үсэг
1	НДГазар	3-р улирал	1500000	4-р улирал	1000000	2,500,000	
2	Галшар		160000		155000	315,000	
3	Баянхутаг		150000		150000	300,000	
4	Баянмөнх		150000		150000	300,000	
5	Дархан		200000		200000	400,000	
6	Дэлгэрхаан		200000		200000	400,000	
7	Жаргалтхаан		200000		200000	400,000	
8	Цэнхэрмандал		200000		200000	400,000	
9	Өмнөдэлгэр		340000		340000	680,000	
10	Баянадрага		220000		220000	440,000	
11	Батноров		220000		220000	440,000	
12	Норовлин		200000		200000	400,000	
13	Дадал		260000		260000	520,000	
14	Батширээт		200000		200000	400,000	
15	Биндэр		210000		210000	420,000	
16	Баяновоо		200000		200000	400,000	
17	Бэрх		160000		160000	320,000	
18	Мөрөн		150000		150000	300,000	
	Нийт		4920000		4415000	9,335,000	
		Үйл ажиллагааны нягтлан бодогч:		А.Оюун			

2025 онд сайн дурын даатгалын хамрагдалтын төлөвлөгөөгөөр шинээр 672 даатгуулагч хамруулахаас 705 даатгуулагч хамруулж хамрагдалтын төлөвлөгөөг 105 хувь биелүүлсэн.



2025 оны байдлаар нийгмийн даатгалд шинээр 95 ажил олгогчийг хамруулсан. Мөн албан журмын даатгуулагчийн тоог 445-аар нэмэгдүүлэн нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан.



2025 онд ААН албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн 265 удаагийн сургалтаар 831 нэгжид сургалт уулзалт хийж, 13391 иргэд, даатгуулагчид сургалт, уулзалтад хамрагдуулан ажилласан байна.





ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Мэдээлэл лавлах албан хаагч:

НЭР	АЛБАН ТУШААЛ	ЦАХИМ ШУУДАН	УТАС	ӨРӨӨНИЙ №
Н.Цолмонбаяр	Захиргаа хяналтын хэлтсийн дарга	tsolmonbayar.n@ndaatgal.mn	88052416	202

